# МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН
# ТУШААЛ

2025 оны 12 сарын 26 өдөр Дугаар 188 Улаанбаатар хот

## Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалт, “Стратеги батлах тухай” Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийн 5.2, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний III үе шатны төлөвлөгөөг хавсралт ёсоор батлсугай.

2.Стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг салбарын сайд, агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд салбар дундын уялдааг хангаж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газар (хошууч генерал Г.Ариунбуян)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга (А.Даваажаргал)-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД Х.ГАНХУЯГ

0025101369

Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 188 дугаар тушаалын хавсралт

# ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭГ МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН III ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ (2026–2030 он)

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүн | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин /он/ | Зорилтот түвшин | | | | | Шаардагдах төсөв | Санхүүгийн эх үүсвэр | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2026 | 2027 | 2028 | 2029 | 2030 | | | Үндсэн | Хамтран |
| **Тэргүүлэх чиглэл 1. Гамшгийн эрсдэлийг бууруулах бүх нийтийн ойлголтыг гүнзгийрүүлэх, мэдлэг олгох** | | | | | | | | | | | | | | |
| Зорилт 1.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах талаар иргэд, олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх | | | | | | | | | | | | | | |
| 1.1.1 | Гамшгаас хамгаалах аюулгүй амьдрах сургалт мэдлэг, ойлголт, чадвар дадал боловсролыг хүүхэд, залуust бүх шатны боловсролын байгууллагаар дамжуулан олгох | Хүүхэд, суралцагчид гамшгийн эрсдэлийг таних, урьдчилан сэргийлэх, аюулгүй зан үйлийг хэвшүүлэх, мэдлэг, чадвар, дадалтай болсон байна | Сургалтын хөтөлбөрт тусган, хэрэгжүүлж буй сургуулийн эзлэх өсөлт | Хувь (өссөн дүнгээр) | 2025/35 | 35 | 40 | 50 | 70 | 85 | 25 сая төгрөг | Улсын төсөв | БЯ | ОБЕГ ОУБ |
| | | | Сургалтын хөтөлбөрт тусган, хэрэгжүүлж буй цэцэрлэгийн эзлэх өсөлт | | 2025/30 | 70 | 100 | | | | | | | |
| 1.1.2 | “Боосай карт”-ыг ерөнхий боловсролын сургуулийн бүх сурагчдад олгож, картан тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн болгох арга хэмжээг хэрэгжүүлэх | Сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашигладаг болсон байна | Ерөнхий боловсролын сургуулийн хамралтын өсөлт | Тоо (өссөн дүнгээр) | 2025/50 | 200 | 300 | 400 | 500 | 600 | 207,4 сая төгрөг | Төсөл хөтөлбөр | БЯ | ОБЕГ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, ОУБ |
| 1.1.3 | Сургууль, цэцэрлэгийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж, эрсдэлийг бууруулж, бэлэн байдлыг хангуулах | Боловсролын байгууллагын барилга байгууламж, сурагчдын гамшигт өртөх эрсдэлийн түвшин буурна | Гамшиг, аюулт үзэгдэл, осолд өртсөн сургууль, цэцэрлэгийн тоо болон сургууль, цэцэрлэгийн насны хүүхэд гамшиг, аюулт үзэгдэл, осолд өртсөн тоог нийт 100.000 | Тоо | 2024/53.7 | 50 | 48 | 46 | 44 | 42 | - | Орон нутгийн төсөв, ОУБ | БЯ | ОБЕГ ҮСХ ЦЕГ |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | . | сурагчид харьцуулсан тооны нийлбэрийн бууралт | | | | | | | | | | | |
| 1.1.4. | НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын "Сургууль, цэцэрлэгийн цогц аюулгүй байдал" санаачилгын хүрээнд жишиг сургуулийг бий болгох | Стандартад нийцсэн, гамшигт тэсвэртэй сургууль, цэцэрлэгийг нэмэгдүүлсэн байна /ЖАЙКА төсөл хөтөлбөрийн зургийн дагуу/ | Жишиг сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийн тоо | Тоо | 2025/4 | | 1 | | 1 | | 3,18 тэрбум төгрөг | Улсын болон орон нутгийн төсөв | БЯ, ХББОСЯ, СЯ | ОУБ, аймаг, нийслэлийн ЗДТГ |
| 1.1.5 | Иргэдийг гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв байгуулах | Гамшиг ослын үед бэлэн байдал, өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвар нэмэгдэнэ | Аймаг, орон нутагт байгуулсан сургалт, арга зүйн төв | Тоо /өссөн дүн/ | 2024/1 | | | 1 | | 2 | 17,2 тэрбум тэрбум төгрөг | Орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж | ГЭБОНЗ, Аймаг, нийслэлийн ЗДТГ | Аймаг, нийслэлийн ОБГ, ОУБ, |
| 1.1.6 | Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилсан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах | Хүн амын мэдлэг, ойлголт, дадал хэвшил нэмэгдэнэ | Нийт хүн амын хамрагдалтын эзлэх хувь | Хувь | 2025/17 | 25 | 30 | 35 | 40 | 45 | 3,5 тэрбум төгрөг | Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн санхүүжилт | ОБЕГ | Аймаг, нийслэлийн ОБГ |
| 1.1.7. | Гамшгаас хамгаалах чиглэлээр эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах | Гамшгаас хамгаалах судалгаа шинжилгээний цар хүрээ нэмэгдэнэ. | Хурал хэлэлцүүлгийн тоо | Тоо | - | 1 | 1 | 1 | 1 | 1 | - | Улсын төсөв, ОУБ | ОБЕГ, ОУБ | Их дээд сургууль, Эрдэм шинжилгээ судалгааны байгууллага |
| 1.1.8 | Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд жендерийн мэдрэмжтэй байдал, эмэгтэйчүүдийн оролцоо, санал санаачилгыг тусгах чиглэлээр бага хурал | Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн зөвлөмж чиглэлд эмэгтэйчүүдийн санал, санаачилга тусаж, хэрэгжсэн байна. | 2 жилд нэг удаа зохион байгуулсан бага хурал (форум, уулзалт, хэлэлцүүлэг) | Тоо | | | 1 | | 1 | | - | Төсөл хөтөлбөрийн санхүүжилт | МУЗН, ОУБ | ОБЕГ, төрийн болон иргэний нийгмийн байгууллага |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | (форум, уулзалт, хэлэлцүүлэг) зохион байгуулах | | | | | | | | | | | | | |
| 1.1.9 | Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулахад зорилтот бүлэг (хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан)-ийн иргэдийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх тусгайлсан сургалтын цогц хөтөлбөр шинэчлэн боловсруулах | Хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан гэсэн зорилтот бүлгийн иргэдэд зориулсан тусгайлсан сургалтын төрөл, хүртээмж нэмэгдсэн байна. | 3 зорилтот бүлэгт зориулсан сургалтын хөтөлбөрийн тоо | Тоо | 1 /хүүхэд/ | | 1 | 1 | 1 | | - | Улсын төсөв, төсөл хөтөлбөрийн санхүүжилт | БЯ, ГБНХЯ, ОБЕГ | ОУБ, иргэний нийгмийн байгууллага |
| Зорилт 1.2. Гамшгийн эрсдэлийг үнэлэх тогтолцоог бий болгож, мэдээллийн сан бүрдүүлэх | | | | | | | | | | | | | | |
| 1.2.1 | Гамшгийн удирдлагын нэгдсэн системийн II хувилбарыг хөгжүүлэх | Гамшгийн эрсдэлийн мэдээлэл, урьдчилан мэдээлэх, шуурхай удирдлага, шийдвэр гаргалтыг нэг платформ дээр нэгтгэсэн, найдвартай, хурдан ажиллагаатай дижитал систем бүрдэнэ | Улсын хэмжээний гамшиг ослын нэгдсэн санг хөгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт | Хувь (өссөн дүнгээр) | 2025/50 | 100 | | | | | 710 сая төгрөг | Улсын төсөв | ОБЕГ | Холбогдох яам, агентлаг |
| 1.2.2 | Аймаг, сум, суурин газруудын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал хийх | Нутаг дэвсгэрийн газар хөдлөлтийн аюулын түвшин, эмзэг хэсгийг нарийвчлан тогтоож, барилга байгууламж, дэд бүтэц, хүн амын суурьшлыг эрсдэлийн үнэлгээтэй уялдуулан | 9 аймагт | Аймгийн тоо | 2025/12 | 2 | 2 | 1 | 2 | 2 | 1.3 тэрбум төгрөг | Улсын болон орон нутгийн төсөв | ХББОСЯ, СЯ, ШУА, Аймгийн ЗДТГ | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | төлөвлөх, бэхжүүлэх боломж бүрдэнэ | | | | | | | | | | | | |
| 1.2.3 | Уур амьсгал, ус цаг уурын гаралтай аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээг нэвтрүүлэх, нарийвчлал сайтай тоон урьдчилсан мэдээний загварчлалыг хөгжүүлэх | Нөлөөлөл, хохирлын таамаглалд суурилсан, нарийвчлал сайтай урьдчилсан мэдээг нэвтрүүлснээр гамшгийн эрсдэлийг эрт үе шатанд бууруулах боломж бүрдэнэ. | Ган, зуд, хүчтэй салхи шуурга, үерийн аюулын урьдчилсан мэдээний загварчлал | Тоо (өссөн дүнгээр) | 2025/1 | 2 | 3 | 4 | | | 300 сая төгрөг | ОУБ, Улсын төсөв | БОУАӨЯ | ЦУОШГ ОБЕГ |
| 1.2.4 | Гамшиг, эрсдэлийн талаарх мэдээллийг салбар хооронд нэгтгэх, байгууллагуудын өгөгдөл, мэдээлэл солилцох техникийн нөхцөлийг бүрдүүлэх | Гамшиг, эрсдэлийн мэдээллийг техникийн түвшинд салбар хооронд нэгтгэж, байгууллагуудын өгөгдөл солилцоо бүрдэнэ. | Салбар хооронд нэгтгэж, байгууллагуудын өгөгдөл солилцоог зохицуулах баримт бичиг | Хувь (өссөн дүнгээр) | 2025/20 | 40 | 60 | 80 | 100 | | - | Улсын төсөв | ЦХИХХЯ, ОБЕГ | Бүх яамд, Аймаг, нийслэлийн ЗД |
| 1.2.5 | Шадар сайдын 2020 оны 22 дугаар тушаалаар батлагдсан "Гамшиг, аюулт үзэгдэл, ослын бүртгэл, гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээний маягт, заавар"-ыг шинэчлэн батлуулах | Гамшгийн мэдээлэл, хохирол, хэрэгцээний үнэлгээний нэгдсэн стандарт, чанар, ашиглалт сайжирна | Боловсруулсан заавар | Хувь | 2020/- | | 100 | | | | - | Улсын төсөв | ОБЕГ | ҮСХ |
| 1.2.6 | Ган, зуд, үер, хүчтэй салхи шуурганы гамшгийн хохирлыг үнэлэх арга зүйг | Хохирлыг бодитой тооцох нөхцөл бүрдэнэ | Ган, зуд, үер, хүчтэй салхи шуурганы гамшгийн хохирлын үнэлгээний батлагдсан аргачлал | Хувь | 2025/30 | | 100 | | | | - | Улсын төсөв | БОУАӨЯ, ОБЕГ | ШУА, ГХУА |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | батлуулах, хохирлыг бодитой тооцох нөхцөлийг бүрдүүлэх | | | | | | | | | | | | | |
| 1.2.7 | Хүчтэй салхи, шуурганы гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар"-ыг боловсруулж, Заавар шинэчлэн батлах тухай МУ-ын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалд нэмэлт оруулж батлуулах | Хүчтэй салхи шуурганы гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх нөхцөл бүрдсэн байна | Батлагдсан үнэлгээний заавар | Хувь | 0 | | 100 | | | | - | Улсын төсөв | ЦУОШГ, ОБЕГ | БОУӨАЯ, ОУБ, Шинжлэх ухааны байгууллага |
| 1.2.8 | Эм, эмнэлгийн хэрэгслийн салбар дундын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн мэдээллийг цахимжуулах | Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн программ хангамж сайжирч, ил, тод байдал хангагдсан байна | Эрүүл мэндийн салбарын нөөцийн цахимжсан эм, эмнэлгийн хэрэгсэл | Хувь (өссөн дүнгээр) | 0 | 10 | 20 | 30 | 70 | 100 | - | ОУБ-ын төсөл | ЭМЯ | ЭЭХХЗГ, ЗӨСҮТ |
| **Тэргүүлэх чиглэл 2. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны удирдлагын засаглалыг бэхжүүлэх** | | | | | | | | | | | | | | |
| Зорилт 2.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох | | | | | | | | | | | | | | |
| 2.1.1 | Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах | Хуулийн нэмэлт өөрчлөлт оруулж батлуулсан хууль | Хуулийн нэмэлт өөрчлөлт | Тоо | - | | 1 | | | | - | Улсын төсөв | БОУАӨЯ ЭЗХЯ СЯ | ОБЕГ |
| 2.1.2 | Гамшгийн эрсдэлийн даатгалын тухай хуулийг батлуулах | Гамшгийн улмаас учрах хохирлыг хувийн болон олон нийтийн даатгалын санхүүжилтээр нөхөн төлөх, улсын төсөвт үзүүлэх шууд дарамтыг бууруулах, иргэн, ААН-ийн эдийн засгийн тэсвэрлэх | Батлагдсан хууль | Тоо | 0 | | | | | 1 | - | Улсын төсөв | СЯ | ОБЕГ, СЗХ, ОУБ |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | чадвар нэмэгдэх нөхцөл бүрдэнэ | | | | | | | | | | | | |
| 2.1.3 | Гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулах | Аюулт үзэгдлийн мэдээлэл хяналт, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа эрх зүйн шинэчлэгдсэн орчинд, илүү нарийвчлалтай, найдвартай, уялдаа холбоотойгоор хэрэгжинэ | Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн Хуулийн шинэчилсэн найруулга | Тоо | 1997/- | | | 1 | | | - | Улсын төсөв | БОУАӨЯ ХЗДХЯ | |
| | | Уур амьсгалын эрсдэлийг бууруулах бодлого, хөрөнгө оруулалт, зохицуулалт нэгдсэн зохион байгуулалттай болж, уур амьсгалын гаралтай гамшгийн бууруулах дасан зохицох чадавх, тогтвортой хөгжлийн үзүүлэлт сайжирна. | Уур амьсгалын өөрчлөлтийн тухай батлагдсан хууль | Тоо | 0 | | 1 | | | | - | Улсын төсөв | БОУАӨЯ ХЗДХЯСЯ | ОБЕГ |
| 2.1.4 | Аюулыг эрт зарлан мэдээлэх, хүн амд шуурхай хүргэх системийн эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх | Олон сувагт, цаг алдалгүй мэдээлэх нэгдсэн тогтолцоо бүрдэж, хүний амь нас, эдийн засгийн хохирлыг бууруулах боломж сайжирна | ЗГ 2015 оны 286, 2011 оны 339-р тогтоолуудын шинэчлэл /нэгтгэж шинэчлэх/ | Тоо | 2 | | | 1 | | | - | Улсын төсөв | БОУАӨЯ, ЦУОШГ, ОБЕГ | ШУА |
| 2.1.5 | Айл өрхийн цахилгааны утасны стандартчилал, | Цахилгааны аюулгүй байдлаас шалтгаалсан гал түймрийн тоо | Батлагдсан журам | Тоо | - | | 1 | | | | - | Улсын төсөв | ОБЕГ, ЭХЯ, СХЗГ | ХББОСЯ, Цахилгаан түгээх компани, Аймаг, |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналтын журам боловсруулах | буурч, эрсдэлийг бууруулж, аюулгүй, найдвартай хэрэглээг хангах нөхцөл бүрдэнэ | | | | | | | | | | | | нийслэлийн ЗДТГ |
| 2.1.6 | Засгийн газрын 2018 оны 327 дугаар тогтоолоор батлагдсан "Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт", "Гамшгийн зэрэглэл тогтоох журам"-ыг шинэчилж, гамшгийн статистик мэдээллийг сайжруулах | Гамшгийн шинж чанар, цар хүрээ, хохирлыг нэг стандарт шалгуураар ангилж, улсын хэмжээнд бодитой, харьцуулагдахуйц статистик мэдээлэлтэй болох нөхцөл бүрдэнэ | Тогтоолын шинэчлэлтийн хувь | Хувь | 2018/- | 50 | 100 | | | | - | Улсын төсөв | ОБЕГ | ҮСХ |
| Зорилт 2.2. Гамшгийн эрсдэлийг бууруулахад түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх | | | | | | | | | | | | | | |
| 2.2.1 | Гамшгаас хамгаалах улсын албадын бэлэн байдлын түвшнийг үе шаттай нэмэгдүүлэх | Томоохон эрсдэл, гамшгийн үед шуурхай, зохион байгуулалттайгаар хариу арга хэмжээ авах чадавх сайжирна | Бэлэн байдлын үнэлгээний дундаж түвшин өсөлт | Хувь | 2025/60 | 65 | 70 | 75 | 80 | 85 | - | Улсын болон орон нутгийн төсөв | ОБЕГ | ГХУА |
| 2.2.2 | Гамшгийн үед бизнесийн тогтвортой үйл ажиллагааны төлөвлөлт хийх чиглэлээр хувийн хэвшлийн байгууллагын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх | Гамшгийн үед хувийн хэвшлийн байгууллагын бизнесийн тогтвортой байдлыг хангах үлгэрчилсэн загвар боловсруулсан байна. | Үлгэрчилсэн загвар | Тоо | 0 | | | 1 | | | - | Улсын болон орон нутгийн төсөв, Хувийн хэвшил, төсөл хөтөлбөр | МҮХАҮТ, ЭЗХЯ, ОУБ, ТББ | СЯ, ОБЕГ |
| 2.2.3 | Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн сургалтын зааврыг батлуулах | Сайн дурын хэсгийн сургалтын зааврыг батлуулах ажлын хэрэгжилт бүрдсэн байна. | 60 доошгүй хувьд сургалт ордог тогтолцоо бүрдэх | Хувь | 0 | 50 | 55 | 60 | 65 | 65 | 50 сая төгрөг | Төсөл хөтөлбөрийн санхүүжилт | ОБЕГ | МУЗН Сайн дурынхны байгууллагуудын сүлжээ" ТББ |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.4 | "Гамшигт тэсвэртэй хот" санаачилгын хэрэгжилтийг хангах, хот суурины гамшигийг даван туулах чадавхыг сайжруулах | Дэд бүтэц, үйлчилгээ, иргэдийн оролцоо гамшигийг даван туулах, хурдан сэргээн босгох чадвартай болно | 21 аймаг, нийслэлийн хотуудын чадавхын дундаж | Хувь | 2025/59.5 | | | | | 65 | - | Орон нутгийн төсөв, ОУБ | ГЭБОН 3-ийн гишүүн байгууллага | Аймаг, нийслэлийн ЗДТГ |
| 2.2.5 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн шуурхай удирдлагын тогтолцоог бий болгох | Шуурхай удирдлагын нэгж байгуулагдсан байна | Байгуулагдсан Шуурхай удирдлагын нэгж | Тоо | | 1 | 3 | 4 | 4 | 4 | - | ОУБ-ын төсөл | ЭМЯ | Аймаг, нийслэлийн ЗДТГ |
| Зорилт 2.3. Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр үндэсний стандартыг боловсронгуй болгох | | | | | | | | | | | | | | |
| 2.3.1 | "Хашаандаа сайхан амьдаръя", "Миний амины орон сууц" хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьсан тохиолдолд 30 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх | Хот суурин газрын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан амины орон сууцны бүсэд БНбД 22-01-01 Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх норм ба дүрэм, Галын аюулгүй байдлын ерөнхий шаардлага хангасан болон эрчим хүчний үр ашигтай хэрэглээг дээшлүүлэх, урьдчилгаа төлбөрийн татаас бүхий эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барихад улсаас дэмжлэг үзүүлсэн байна | Иргэдэд мэдээлэл хүргэх, нөлөөллийн ажил хийх, үйлчилгээ үзүүлсэн тоо (Амины орон сууц шинээр барих болон сайжруулахад төрөөс татаас олгох журам дэмжлэгийн хүрээнд баригдах амины орон сууц) | Тоо | 2025/29.562 | 30.000 | 30.000 | 30.000 | 40.000 | | - | Улсын болон орон нутгийн төсөв | ХББОСЯ, СЯ, ЗГХЭГ Монгол банк | АНЗД |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3.2 | Гамшиг, уур амьсгалын эрсдэлийн үнэлгээнд суурилан барилга, дэд бүтцийн холбогдох стандарт, нормыг шинэчлэх | Сэргээн баригдах байгууламжууд байгалийн болон уур амьсгалын аюулд тэсвэртэй, аюулгүй, тогтвортой байх нөхцөл бүрдэнэ. | Барилга байгууламжийн норм нормативын баримт бичгийн тоо | Тоо | 2025/5 | 2 | 2 | 5 | 5 | 5 | - | Улсын төсөв | ХББОСЯ, БХТ | Бүх яамд |
| **Тэргүүлэх чиглэл 3. Эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх** | | | | | | | | | | | | | | |
| Зорилт 3.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх | | | | | | | | | | | | | | |
| 3.1.1 | Хот, суурин газрыг үерийн эрсдэлд тэсвэртэй, тогтвортой хөгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх | Хот, суурин газарт орон зайн дүн шинжилгээ хийгдэж, үерийн аюулын зураг боловсруулагдсан байна | Хот, суурин газарт үерийн эрсдэлийг тооцох орон зайн дүн шинжилгээг ерөнхий болон нарийвчилсан байдлаар хийж үерийн аюулын зураг | Суурин газрын тоо | - | 36 | 50 | 50 | 50 | 50 | - | Улсын болон орон нутгийн төсөв, ОУБ | ГЭБҮЗ ХББОСЯ БОУАӨЯ ГЗБГЗЗЕГ Усны газар ОБЕГ | Аймгийн ЗДТГ, ГЭБОНЗ |
| | | Хот, суурин газарт инженерийн бэлтгэл ажлыг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдсан байна | Хот, суурины инженерийн бэлтгэл ажлыг шинээр болон шинэчилж арга хэмжээний төлөвлөгөө | Аймгийн тоо | - | 8 | 8 | 5 | - | - | - | Улсын болон орон нутгийн төсөв | ХББОСЯ 21 аймгийн ЗДТГ, Ерөнхий архитектор | Аймгийн ЗДТГ, ГЭБОНЗ |
| | | Нийслэлийн төлөвлөгөө үе шаттай хэрэгжсэн байна | Нийслэлийн Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт зардлын тусгасан хувь | Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн эзлэх хувь /төсөвт эзлэх хувь/ | - | 0.2 | 0.2 | 0.2 | 0.2 | 0.2 | - | Улсын болон орон нутгийн төсөв | ХББОСЯ Нийслэлийн ЗДТГ | Нийслэлийн ХБХСГ ГУББГ |
| 3.1.2 | Үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх нэн шаардлагатай допплерийн радарын станцыг 3 аймагт байгуулах | Хүчтэй аадар бороо, үерийн эрсдэлийг нарийвчлалтай, богино хугацаанд тодорхойлж, урьдчилан анхааруулах чадавх сайжирна | Станц байгуулсан аймгийн тоо | Тоо | 2025/1 (өссөн дүнгээр) | 2 | 3 | 4 | | | 30 тэрбум төгрөг | Улсын төсөв, ОУБ, төсөл хөтөлбөр | БОУАӨЯ, ЦУОШГ | СЯ, ОУБ |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.3 | Цаг агаарт зориудаар нөлөөлөх явуулын радар шинээр байгуулах | Хур тунадас үүсгэх, багасгах ажиллагааг нарийвчлалтай төлөвлөж хэрэгжүүлэх боломж нэмэгдэж, ган, мөндөр, хүчтэй аадар борооны сөрөг нөлөөллийг бууруулах чадавх сайжирна | Явуулын радарын тоо | Тоо | 0 | | | 1 | 2 | | - | Улсын болон орон нутгийн төсөв, ОУБ | БОУАӨЯ | ЦУОШГ |
| 3.1.4 | Гамшгийн шалтгаан нөхцөл, галын аюулгүй байдлын үзүүлэлт, барилга байгууламжийн хийц, бүтээцийн чанарыг тодорхойлох үзүүлэлтийн төрлийг нэмэгдүүлэх хүрээнд лабораториудын хүчин чадлыг сайжруулах | Осол, гамшгийн эрсдэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитой үнэлж, стандарт шаардлагыг хатуу мөрдүүлэх боломж нэмэгдэнэ | Барилгын бат бэхийн чанар, шалтаан нөхцөлийг тодорхойлох үзүүлэлтийн тоо | Тоо (өссөн дүнгээр) | 2025/13 | | 18 | | 21 | | - | Улсын болон орон нутгийн төсөв, ОУБ | ОБЕГ | ХББОСЯ |
| 3.1.5 | Хөрсний хурдатгал хэмжигч багаж суурилуулж, станцын дэд бүтцийг байгуулах | Хүчтэй газар хөдлөлтийн хөрсний чичирхийллийг тооцоолох чадавх нэмэгдэнэ | Хөрсний хурдатгал хэмжигч 10 станц | Тоо (өссөн дүнгээр) | 2025/4 | 6 | 8 | 10 | 12 | 14 | 69,7 сая төгрөг | Улсын болон орон нутгийн төсөв | НЗДТГ, ШУА-ийн ООГФХ | ХББОСЯ |
| Зорилт 3.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх | | | | | | | | | | | | | | |
| 3.2.1 | Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хийгдсэн судалгаанд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх | Гамшгийн эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх хүрээнд Шинжлэх ухаан технологийн сангаас оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэнэ | Судалгааны ажилд зарцуулсан хөрөнгийн эзлэх хувь | Хувь | 0 | | | | | 5 | - | Улсын төсөв | ЭЗХЯ | ОБЕГ, ШУ-ны байгууллагууд |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.2 | Эрүүл мэндийн байгууллагын гамшгийн эрсдэлийг бууруулах | Эрүүл мэндийн байгууллагын газар хөдлөлтөд тэсвэртэй барилгын тоо нэмэгдсэн байна. | Газар хөдлөлтийн эрсдэлийн тооцоо хийсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | Хувь (өссөн дүнгээр) | - | 10 | 20 | 40 | 70 | 100 | - | Олон улсын төсөл хөтөлбөр | ЭМЯ | СЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ |
| | | | Барилгын хүчитгэл хийсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | Тоо | 2025/1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | - | Улсын болон орон нутгийн төсөв | ЭМЯ | СЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ |
| **Тэргүүлэх чиглэл 4. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх, шинээр барьж байгуулах үйл ажиллагааг урт хугацаанд төлөвлөн хэрэгжүүлэх** | | | | | | | | | | | | | | |
| Зорилт 4.1. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлж, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх | | | | | | | | | | | | | | |
| 4.1.1 | Бүх шатны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг гамшгийн эрсдэлийн мэдээлэлд суурилан сайжруулах | Бодит эрсдэлд тохирсон, уялдаа холбоотой, давхардалгүй төлөвлөгөөтэй болж, хор уршгийг арилгах арга хэмжээний үр нөлөө нэмэгдэнэ | Төлөвлөгөөний тоо | Тоо (өссөн дүнгээр) | - | 36 | 111 | 211 | 411 | 661 | - | Улсын болон орон нутгийн төсөв | ОБЕГ | Бүх албад |
| 4.1.2 | Монгол Улсад гамшгийн аюулын эрт зарлан мэдээлэх нэгдсэн тогтолцоог сайжруулах | Хүн амыг цаг алдалгүй сэрэмжлүүлж, хүний амь нас, эд хөрөнгө, дэд бүтцэд учрах хохирлыг бууруулах боломж нэмэгдэнэ | Эрт сэрэмжлүүлгийн системээр хамрагдсан хүн 100,000 хүн ам тутамд хүргэх хувь 80%-аас дээш | Хувь (өссөн дүнгээр) | - | 20 | 40 | 60 | 80 | 100 | 32 сая ам.доллар | ОУБ, төсөл хөтөлбөр | ОБЕГ | СЯ, ОУБ |
| 4.1.3 | Олон сувагт (SMS, радио, ТВ, апп, цахим самбар г.м) эрт сэрэмжлүүлэх систем нэвтрүүлэх | Хүн амыг цаг алдалгүй сэрэмжлүүлж, хүний амь нас, эд хөрөнгө, дэд бүтцэд учрах хохирлыг бууруулах боломж нэмэгдэнэ | Аймаг, нийслэл, сум, дүүрэгт бүрэн нэвтэрсэн хувь | Хувь (өссөн дүнгээр) | - | 20 | 40 | 60 | 80 | 100 | - | Улсын болон орон нутгийн төсөв, ОУБ, төсөл хөтөлбөр | ОБЕГ | ЦХИХХЯ, ОУБ |
| 4.1.4 | Гамшгийн үед түр цугларах талбай, түр орон байр, нүүлгэн шилжүүлэх байршлыг тавигдах шаардлагад | Иргэдийг аюулгүй, зохион байгуулалттай байрлуулах, үйлчилгээ хүргэх чадавх сайжирна | Түр цугларах талбай, түр орон байр, нүүлгэн шилжүүлэх байршлын тавигдах шаардлагад нийцсэн эзлэх хувь | Хувь | 2025/0,5 | 1 | 3 | 5 | 7 | 10 | - | Улсын болон орон нутгийн төсөв, ОУБ, төсөл хөтөлбөр | Аймаг, нийслэлийн ЗДТГ | ОБЕГ |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нийцүүлэх, түр орон байрыг тоноглох, бэлэн байдлыг хангуулах | | | | | | | | | | | | | |
| 4.1.5 | Гамшиг, ослын улмаас хот, суурин газарт шилжин суурьшсан иргэдийн хөдөлгөөнийг тодорхойлж, тэдний нийгмийн хамгаалал, аж амьдралыг дэмжих иж бүрэн тогтолцоог бий болгож хэрэгжүүлэх | Шилжин суурьшсан иргэдийн хөдөлгөөн, хэрэгцээг нарийвчлан тогтоож, нийгмийн хамгааллын иж бүрэн тогтолцоогоор дэмжсэнээр шилжиж ирэгсдийн амьжиргаа, тогтвортой байдал сайжирна | Гамшгийн улмаас шилжин суурьшсан иргэдийн албан ёсны бүртгэл, мэдээллийн сан бүрдсэн эсэх | Хувь | 0 | 20 | 40 | 60 | 80 | 100 | - | Улсын болон орон нутгийн төсөв, ОУБ | ГБХНХЯ УБЕГ | НҮБ-ын ШХБ |
| 4.1.6 | Гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох, урт хугацаанд сэргээн босгох үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулах | Гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох, урт хугацаанд сэргээн босгох үйл ажиллагааны удирдлага зохицуулалт оновчтой тодорхойлогдсон байна | Боловсруулсан холбогдох эрх зүйн баримт бичиг | Хувь | - | | | | | 100 | - | Улсын төсөв | ОБЕГ | ГХМА, байгууллагууд |
| 4.1.7 | Зоонозын халдварт өвчний үед ажиллах хүчин чадлыг нэмэгдүүлэх | Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн лаборатори магадлан итгэмжлэгдсэн байна | Лабораторийн чадавх сайжруулах төслийн хэрэгжилт | Хувь (өссөн дүнгээр) | - | 20 | 30 | 50 | 70 | 100 | - | Улсын болон орон нутгийн төсөв | ЭМЯ | СЯ, ЗӨСҮТ |
| 4.1.8 | Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх | Алба хаагчдын мэдлэг, ойлголт, мэргэшлийн ур чадвар нэмэгдэнэ | Нийт офицер бүрэлдэхүүний магистр ба түүнээс дээш зэрэгтэй алба хаагчийн эзлэх хувь | Хувь /өссөн дүнгээр/ | 2025/19.5 | | | 21 | | 22.5 | - | Улсын болон орон нутгийн төсөв | ОБЕГ | |
| | | | Төрөл мэргэжлийн сургалтад хамрагдсан аврагч, гал | Хувь /өссөн дүнгээр/ | 2025/1887 | 10 | 15 | 20 | 25 | 30 | - | Улсын болон орон | ОБЕГ | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сөнөөгчийн тоог суурь түвшинтэй харьцуулсан хувь | | | | | | | | | нутгийн төсөв | | |
| | | Төвийг өргөжүүлэх, шинээр байгуулах | Мэргэжлийн тусгай сургалт бэлтгэлийн төвийн тоо | Тоо | 0 | | | 1 | | | - | Улсын болон орон нутгийн төсөв, ОУБ | ОБЕГ | |
| 4.1.9 | Гал түймэр унтраах, эрэн хайх, аврах нэгжийг орон нутаг шинээр нэмж байгуулах, дэвшилтэт технологи бүхий тусгай зориулалтын автомашин, техник, багаж, хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх | Шинээр анги, нэгж байгуулж хамрах хүрээ нэмэгдэнэ. | Шинээр байгуулах нэгжийн тоо | Тоо/хувь | 2024/14/53.1 | 5/57.3 | 5/59.4 | 5/61.5 | 5/62 | 5/62.5 | - | Улсын болон орон нутгийн төсөв | ОБЕГ | СЯ |
| | | Техник хэрэгслийн чадавх нэмэгдэнэ. | Тусгай зориулалтын автомашин, техник хэрэгслийн хангалт | Хувь | 2024/56 | 68 | 73 | 78 | 79 | 80 | - | Улсын болон орон нутгийн төсөв | ОБЕГ | СЯ |
| 4.1.10 | Гамшгаас урьдчилан сэргийлэх сайн дурын идэвхтэн сургагч багш бэлтгэх | Багш, сайн дурын идэвхтэн бэлтгэсэн байна | 1/3500 сургагч багшийн нэмэгдсэн тоо | Тоо | 164 | 170 | 170 | 170 | 170 | 170 | 157,5 сая төгрөг | ОУБ, Төсөл хөтөлбөр ийн санхүүжилт | МУЗН | ОБЕГ, ОУБ |
| 4.1.11 | Сайн дурын идэвхтэн сургагч багш нарыг цахимаар болон бичгээр бүртгэж, мэдээллийг нь төрөл, байршил, сургалтын чиглэлээр ангилан нэгтгэсэн үндэсний нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бий болгож тогтмол шинэчилж ажиллах | Сайн дурын идэвхтэн сургагч багш нарыг шуурхай дайчлан оролцуулах, чадавхжуулах, мэдээлэлд суурилан төлөвлөх боломж бүрдсэн байна | Сайн дурын идэвхтэн сургагч багшийн бүртгэл, мэдээллийн сан хөгжүүлэх хэрэгжилт | Хувь (өссөн дүнгээр) | 0 | 50 | 100 | | | | 70 сая төгрөг | Төсөл хөтөлбөр ийн санхүүжилт | МУЗН, ОУБ | ОБЕГ, "Сайн дурынхны байгууллагуудын сүлжээ" ТББ |
| 4.1.12 | Сайн дурын аврах, гал унтраах хэсэг бүлгийг | ОББ-ын салбар нэгжгүй сум орон нутагт аврах, гал | Сайн дурын гал унтраах хэсэг бүлгийн ажиллах эрх зүйн зохицуулалт бүрдсэн, | Тоо /сумаар/ Өссөн дүнгээр | | 5 | 10 | 15 | 20 | 25 | 500 сая төгрөг | Улсын болон орон нутгийн | Аймаг, нийслэлийн ЗДТГ, | МУЗН ОУБ |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | томилгоожуулж бэлтгэх, анхан шатны тоног төхөөрөмжөөр хангах | унтраах чадавхи бэхжсэн байна. | бэлэн байдал хангагдсан байна. | | | | | | | | | төсөв, ОУБ | ОБГ | |
| 4.1.13 | Гамшиг, онцгой байдлын үеийн нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эмч, эмнэлгийн ажилтны нөөцийн бэлэн байдлыг хангах | Гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүний нөөцийн чадавх нэмэгдсэн байна. | Бэлтгэгдсэн сургагч багш | Тоо | 0 | 10 | 20 | | | | - | Улсын болон орон нутгийн төсөв, ОУБ | ЭМЯ | ОУБ, Аймаг, нийслэлийн ЗДТГ |
| | | | Сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтэн | Тоо | 0 | - | 100 | 200 | 200 | 200 | - | Улсын болон орон нутгийн төсөв, ОУБ | ЭМЯ | ОУБ, Аймаг, нийслэлийн ЗДТГ |
| Зорилт 4.2. Гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх, шинээр барьж байгуулах үйл ажиллагааг сайжруулах | | | | | | | | | | | | | | |
| 4.2.1 | Газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээгээр ашиглалтын шаардлага хангахгүй барилга, байгууламжийг дахин төлөвлөн барилгажуулах | Газар хөдлөлт зэрэг гамшгийн хүн амын аюулгүй байдал, үйлчилгээний тасралтгүй ажиллагаа хангагдана | Хүчитгэсэн болон шинээр барьсан барилга байгууламжийн тоо | Тоо | 2025/1 | 2 | 2 | 1 | 1 | 1 | - | Улсын болон орон нутгийн төсөв, ОУБ | ХББОСЯ, СЯ | Нийслэлийн ЗДТГ |
| 4.2.2 | Гамшгийн үед аврах, яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах стандарт төвүүдийг байгуулах | Стандартын дагуу бүрдүүлж, хадгалдаг төвүүдтэй болж, яаралтай тусламжийн тасалдал буурна | Стандартын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн төвийн хамрагдсан аймаг, бүсийн хувь | Хувь (өссөн дүнгээр) | - | 20 | 40 | 60 | 80 | 100 | - | Улсын төсөв, ОУБ, Олон улсын төсөл хөтөлбөр | ЭМЯ | СЯ |
| 4.2.3 | Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах | Шинээр ойн зурвас байгуулж, ой, хээрийн түймэрт өртөх талбайн хэмжээ буурна Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн чадавх нэмэгдэнэ | Нийт газар нутагт ой, хээрийн түймэрт өртсөн талбайн эзлэх хувийн бууралт | Хувь (бууралт) | 2025/0,78 | 0,7 | 0,6 | 0,5 | 0,45 | 0,4 | - | Улсын боон орон нутгийн төсөв | БОУАӨЯ ОБЕГ | Ойн газар, Бүх шатны ЗДТГ |

ТОВЧИЛСОН НЭР:

Яамд

| | |
|---|---|
| БОУАӨЯ | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам |
| БХЯ | Батлан хамгаалах яам |
| БЯ | Боловсролын яам |
| ГХЯ | Гадаад харилцааны яам |
| ГБХНХЯ | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| ХББОСЯ | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам |
| ХХААХҮЯ | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам |
| СЯ | Сангийн яам |
| ЦХИХХЯ | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам |
| ЭЗХЯ | Эдийн засаг, хөгжлийн яам |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ШСАА | Шадар сайдын Ажлын алба |

Засгийн газрын агентлаг, бусад байгууллага:

| | |
|---|---|
| ГХМА | Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги |
| ГХУА | Гамшгаас хамгаалах улсын алба |
| ГЭБОНЗ | Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ЗӨСҮТ | Зоонозын өвчин судлалын үндэсний төв |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| МУЗН | Монголын Улаан загалмай нийгэмлэг |
| МҮХАҮТ | Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим |
| НЗДТГ | Нийслэлийн Засаг даргын тамгын газар |
| НОБГ | Нийслэлийн Онцгой байдлын газар |
| НҮБ-ын ШХБ | Нэгдсэн үндэстний байгууллагын Шилжилт хөдөлгөөний байгууллага |
| ОБЕГ | Онцгой байдлын ерөнхий газар |
| ООГФХ | Одон орон, геофизикийн хүрээлэн |
| ОБГ | Онцгой байдлын газар |
| ОУБ | Олон улсын байгууллага |
| СЗХ | Санхүүгийн зохицуулах хороо |
| СХЗГ | Стандарт, хэмжил зүйн газар |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| ЦУОШГ | Цаг уур, орчны шинжилгээний газар |
| ШУА | Шинжлэх ухааны академи |
| ЭЭХХЗГ | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар |

---oOo---